

ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ, ТӨЛБӨРТЭЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах, шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах, түүний эд хөрөнгийг олж тогтоох, төлбөр төлөгч, эд хөрөнгийн талаар төлбөртэй мэдээлэл авах ажиллагаанд энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

1.2.Эрэн сурвалжлах ажиллагаа гэж төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоохоор тодорхой нутаг дэвсгэрт явуулж байгаа ажиллагааг ойлгоно.

1.3.Энэхүү журам нь хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр явагдаж буй ялтанг эрэн сурвалжлах ажиллагаанд хамаарахгүй.

Хоёр.Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах шийдвэр гаргах

2.1.Шийдвэр гүйцэтгэгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан арга хэмжээг гүйцэтгэсэн боловч төлбөр төлөгчийн оршин суугаа /оршин байгаа/ газар тодорхойгүй тохиолдолд төлбөр төлөгчийг олж тогтоох, эрэн сурвалжлах саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргана.

2.2.Энэ зүйлийн 2.1-д заасан саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгч хянаж, үндэслэлтэй бол төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах тухай шийдвэр гаргана.

2.3.Төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах шийдвэрт дараах зүйлийг тусгана.

2.3.1.эрэн сурвалжлах үндэслэл

2.3.2.төлбөр төлөгч иргэний овог нэр, хуулийн этгээдийн нэр, регистрын дугаар,

2.3.4.төлбөр төлөгчтэй хамаарал бүхий этгээдийн мэдээлэл

2.3.5.бусад мэдээлэл

2.4.Эрэн сурвалжлах шийдвэрт төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаа, гүйцэтгэх баримт бичигт заагдсан хаяг эсхүл сүүлийн оршин сууж байсан хаягийн талаарх холбогдох баримт бичгийг хавсаргана.

2.5.Ахлах шийдвэр гүйцэтгэгч эрэн сурвалжлах ажиллагааг гүйцэтгүүлэх тогтоолыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 257 дугаар зүйлийн 257.7-д заасан чиг үүрэг бүхий нэгж /алба хаагч/-д хүргүүлнэ.

Гурав.Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах

3.1.Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах шийдвэрийг хүлээн авсан даруйд эрэн сурвалжлах ажилтан хувийн хэрэг нээж, эрэн сурвалжлах ажиллагааг эхлүүлнэ.

3.2.Эрэн сурвалжлах тухай шийдвэрт заасан үндэслэлийг шалган тогтоох чиглэлээр шаардлагатай мэдээлэл, түүний дотор төлбөр төлөгч эхсүл эд хөрөнгийн талаарх мэдээллийг цуглуулна.

3.3.Мэдээлэл цуглуулах ажиллагаатай холбогдуулан шийдвэр гүйцэтгэлийн хувийн хэрэгтэй танилцах, холбогдох баримт бичгийг хуулбарлан авч болно.

3.4.Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах дараах ажиллагааг явуулна.

3.4.1.төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжилж байгаа тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх;

3.4.2.эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний хөрөнгийн талаарх эрх бүхий байгууллагаас мэдээлэл авах, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ач холбогдол бүхий мэдээллийг төлбөртэй авах;

3.4.3.эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний өмчлөл, эзэмшлийн эсхүл нуун далдалсан эд хөрөнгийг шалгах зорилгоор хүн, хуулийн этгээдийн баримт бичгийг шалгах, тайлбар тодорхойлолт гаргуулан авах, тэдгээрийн бие, эд зүйл болон орон байр, барилга байгууламж, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, үзлэг нэгжлэг хийх, холбогдох баримт бичиг, мэдээллийг шалгах;

3.4.4.эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн талаар аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс эсхүл эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцох.

3.5.Эрэн сурвалжлах эрх бүхий ажилтан нь эрэн сурвалжлагдаж буй төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан үүсгэж, улирал тутам мэдээллийг Шийдвэр гүйцэтгэх албаны мэдээлэл, лавлагаа, дүн шинжилгээ хариуцсан нэгжид хүргүүлнэ.

3.6.Энэ зүйлийн 3.5-д заасан нэгдсэн мэдээллийн санг улсын хэмжээнд Шийдвэр гүйцэтгэх алба нэгтгэн, үйл ажиллагаанд хяналт тавина.

Дөрөв. Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн талаар төлбөртэй мэдээлэл авах, зардал тооцох

4.1.Эрэн сурвалжлах ажилтан нь шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн, эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн талаар иргэнээс төлбөртэй мэдээлэл авч болно. Төлбөртэй мэдээллийн нууцлалыг хадгална.

4.2.Эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгчийн талаарх төлбөртэй мэдээллийн хэмжээг дараах байдлаар тооцно.

4.2.1.төлбөр төлөгчийн талаарх ач холбогдол бүхий мэдээллийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хүртэл хувиас хэтрэхгүй байна;

4.2.2.төлбөр төлөгчийн нуугдмал эд хөрөнгийн талаарх ач холбогдол бүхий мэдээллийг мэдээлэгч иргэнтэй харилцан тохиролцон тогтооно. Төлбөртэй мэдээлэл авах дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

4.3.Энэ зүйлийн 4.2-д заасан мэдээлэл үндэслэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд төлбөрийг олгоно.

4.4.Эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгчийг нийтэд мэдээлэх зардал, мэдээлэл авах төлбөрийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлаас суутган тооцно.

4.5.Эрэн сурвалжлах ажилтан нь эрэн сурвалжлах ажиллагааны зардлын тайлан тооцоог гарган энэ журмын 2.2-д заасан шийдвэр гаргасан ахлах шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлнэ.

4.6.Ахлах шийдвэр гүйцэтгэгч зардлын тооцоо, холбогдох баримт бичигтэй хянаж, эрэн сурвалжлах ажиллагааны зардлыг олгоно.

Тав. Эрэн сурвалжлагдсан төлбөр төлөгчийг хүлээлгэн өгөх

5.1.Эрэн сурвалжлах ажиллагаагаар олж тогтоосон эд хөрөнгө, төлбөр төлөгчийн талаарх мэдээлэл эсхүл төлбөр төлөгчийг шийдвэр гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө.

5.2.Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн талаарх мэдээлэл болон төлбөр төлөгчийг хүлээн авсан талаар тэмдэглэл үйлдэж, эрэн сурвалжлах ажиллагааны хувийн хэрэгт хавсаргана.

5.3.Шийдвэр гүйцэтгэгч хүлээн авсан төлбөр төлөгчийг түүний гэр бүл, төрөл садан, хамаарал бүхий 2-оос доошгүй хүний батлан даалтад шилжүүлнэ.

5.4.Шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох хүртэл хугацаанд төлбөр төлөгчийг ирүүлэх үүргийг батлан даагчид мэдэгдэх хуудсаар хүлээлгэнэ. Мэдэгдэх хуудсаар хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа. Эрэн сурвалжлах ажиллагааг дуусгавар болгох

6.1.Эрэн сурвалжлах ажилтан нь төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах ажиллагааг дараах үндэслэлээр дуусгавар болгоно.

6.1.1.эрэн сурвалжлах шийдвэрийг үндэслэн төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг олж тогтоосон;

6.1.2.эрэн сурвалжлагдаж байгаа хүн нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон, гадаадад зорчсон, цагаачилсан;

6.1.3.эрэн сурвалжилж буй үндэслэл арилсан эсхүл төлбөр авагчаас эрэн сурвалжлах ажиллагааг зогсоох хүсэлт гаргасан;

6.1.4.эрэн сурвалжлах тухай шийдвэрийг эрх бүхий этгээдийн шийдвэрээр хүчингүйд тооцогдсон;

6.1.5.шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн, дуусгавар болгосон, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаасан.

6.2.Эрэн сурвалжлах ажиллагаа дуусгавар болсон бол хувийн хэргийг хааж, албан хэрэг хөтлөлтийн шаардлагад нийцүүлэн хадгаламжийн нэгж үүсгэн, архивт шилжүүлнэ.

Долоо.Бусад зүйл

7.1.Эрэн сурвалжлах ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, энэ журамд заасан үндэслэл, журмаас гадуур явуулахыг хориглоно.

7.2.Энэ зүйлийн 7.1 дэх заалтыг зөрчин эрэн сурвалжлах ажиллагаа явуулсан албан тушаалтанд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---